

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/94/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Мөнхжин Утас: 51-261740 Цахим хаяг: mukhjind@audit.gov.mn Аудитор: Г.Тэлмүүн Утас: 51-261740 Цахим хаяг: telmuung@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	22
5.1 Төлбөрийн акт	22
5.2 Албан шаардлага.....	23
5.3 Зөвлөмж	28
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	31

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГХХГ	Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар
НҮТББ	Нийтийн үйлчилгээний төрийн бус байгууллага
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТББ	Төрийн бус байгууллага
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТҮ	Төрийн үйлчилгээний
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/374
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй 2,555,020.3 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг бөгөөд мөн өргөн тархсан байна. Тухайлбал:

- Төсвийн төсөлд тусгаж, батлуулаагүй нийт 239,239.6 мянган төгрөг, байгууллагын үйл ажиллагаанд ашиглаагүй 9 судалгааны ажилд нийт 158,470.0 мянган төгрөгийг тус тус үр ашиггүй зарцуулсан;
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс бараа, ажил, үйлчилгээг шууд худалдан авах аргаар зохион байгуулахын тулд төсөвт өртгийг хуваасан, байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгж, албан тушаалын жагсаалтад гэрээт шинжээч, судлаач, зөвлөхийн орон тоо батлан, гэрээт ажилтантай шууд хөдөлмөрийн гэрээ байгуулж, төрийн албаны цалингийн шатлалын дагуу 419,214.0 мянган төгрөгийг цалингийн сангаас цалинжуулсан;
- Байгууллагын ахлах хянан шалгагч болон хянан шалгагчид төсвийн төсөлд тусгаагүй, 40 хүртэлх хувийн нийт 144,811.2 мянган төгрөгийн нэмэгдэл цалинг үндсэн цалингаас цалингийн зөрүү хэсэгт тооцож олгосон;

- Төсвийг зохистой удирдаагүйгээс 488,268.5 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 сарын 09 өдрийн 22 дугаар тогтоолын дагуу татан буугдсан зарим үндэсний хороодын хөрөнгийг шилжүүлэхтэй холбоотойгоор Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 475 дугаар тогтоолын дагуу 152,392.2 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн “Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ” гэж заасны дагуу байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоог 9.0 хувиар бууруулах арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	426,308,344.46	313,522,078.75
33	АВЛАГА	76,809,614.60	17,500,933.72
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,469,364.76	17,405,590.71
33500	Бусад авлага	73,340,249.84	95,343.01
33510	Байгууллагаас авах авлага	73,340,249.84	95,343.01
34	УРЬДЧИЛГАА	111,308,339.00	73,382,000.00
34710	Урьдчилгаа тооцоо	111,308,339.00	73,382,000.00
34714	Томилолтын урьдчилгаа	111,308,339.00	73,382,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	238,190,390.86	222,639,145.03
35100	Түүхий эд материал	9,588,000.00	11,952,100.00
35110	Тусгай зориулалттай материал	9,588,000.00	11,952,100.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	106,321,429.00	102,075,429.00
35400	Хангамжийн материал	122,280,961.86	108,611,616.03
35410	Бичиг хэргийн материал	32,261,955.34	24,786,800.87
35420	Аж ахуйн материал	7,949,827.26	16,053,767.26
35430	Сэлбэг хэрэгсэл	5,739,510.00	6,073,710.00
35440	Түлш, шатах тослох материал	10,159,559.30	30,724.94
35450	Барилгын засварын материал	19,500,000.00	-
35460	Хүнсний материал	1,760,397.00	2,089,174.00
35470	Бусад хангамжийн материал	44,909,712.96	59,577,438.96
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,752,475,683.10	1,763,199,989.60
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,752,475,683.10	1,763,199,989.60
39200	Биет хөрөнгө	1,424,455,782.43	1,453,677,077.13
39203	Авто-тээврийн хэрэгсэл	602,900,000.00	602,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(477,285,104.31)	(517,373,557.81)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,264,257,467.06	1,611,394,167.06
39206	Хуримтлагдсан элэгдэл	(443,022,040.41)	(743,087,867.23)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	536,747,746.16	621,881,300.16
39208	Хуримтлагдсан элэгдэл	(111,740,747.81)	(165,133,100.72)
39214	Бусад үндсэн хөрөнгө	73,944,994.80	73,944,994.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	(21,346,533.06)	(30,848,859.13)
39300	Биет бус хөрөнгө	328,019,900.67	309,522,912.47
39301	Програм хангамж	93,922,700.00	93,922,700.00

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,902,799.33)	(25,399,787.53)
39303	Бусад биет бус хөрөнгө	241,000,000.00	241,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,178,784,027.56	2,076,722,068.35
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	488,268,480.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	488,268,480.00
41300	Өглөг	-	488,268,480.00
41360	Бусад өглөг	-	488,268,480.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	250,747,790.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	3,800,000.00
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	-	233,720,690.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,178,784,027.56	1,588,453,588.35
51	Засгийн газрын хувь оролцоо	2,178,784,027.56	1,588,453,588.35
51200	Хуримтлагдсан үр дүн	2,178,784,027.56	1,588,453,588.35
51210	Өмнөх үеийн үр дүн	-	2,195,259,190.64
51220	Тайлант үеийн үр дүнү	2,178,784,027.56	(606,805,602.29)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,178,784,027.56	2,076,722,068.35

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	15,472,199,442.66	14,673,037,647.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,082,640,842.66	14,673,037,647.30
120	Нийтлэг татварын бус орлого	1,082,640,842.66	135,891,684.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	69,412,937.22	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	69,412,937.22	-
120009	Бусад орлого	22,000.00	280,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	948,664,607.44	135,611,684.30
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	64,541,298.00	-
122	Тусламжийн орлого	-	14,537,145,963.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	14,537,145,963.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	14,537,145,963.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	14,537,145,963.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	14,389,558,600.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	14,389,558,600.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	14,389,558,600.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	13,173,958,824.95	15,279,843,249.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,173,958,824.95	15,279,843,249.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,976,557,491.95	12,736,286,320.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,417,394,719.32	9,362,488,763.20
210101	Үндсэн цалин	2,702,460,573.36	5,768,446,389.47

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210102	Нэмэгдэл	839,095,600.26	1,667,524,996.96
210103	Унаа хоолны хөнгөлөлт	441,134,564.51	1,040,232,126.77
210104	Урамшуулал	434,703,981.19	886,285,250.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	542,982,525.20	1,138,983,525.27
210201	Тэтгэврийн даатгалын зардал	369,460,827.14	771,641,249.79
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	44,319,655.19	93,656,193.70
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	22,159,828.08	48,171,782.52
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	21,370,357.31	45,100,959.80
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	85,671,857.48	180,413,339.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	185,578,100.00	27,769,500.00
210301	Гэрэл, цахилгаан	22,080,000.00	-
210302	Түлш, халаалт	41,957,100.00	-
210303	Цэвэр, бохир ус	8,153,200.00	-
210304	Байрны түрээс	113,387,800.00	27,769,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	158,901,615.37	110,833,184.58
210401	Бичиг хэрэг	34,817,574.16	28,622,581.00
210402	Тээвэр, шатахуун	21,971,479.91	17,505,864.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	37,220,219.27	55,823,488.69
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	64,892,342.03	8,881,250.69
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	392,851,533.46	31,634,249.96
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,665,779.00	-
210602	Тавилга	13,635,200.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	938,387.45	-
210604	Урсгал засвар	376,612,167.01	31,634,249.96
2107	Томилолт, зочны зардал	689,314,508.00	296,678,327.00
210701	Гадаад албан томилолт	488,052,803.00	131,798,254.00
210702	Дотоод албан томилолт	201,261,705.00	164,880,073.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,220,082,507.00	1,127,765,945.58
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	927,730,117.00	1,041,472,953.00
210803	Даатгалын үйлчилгээ	666,252.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	726,796.00	2,022,444.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	290,838,342.00	84,270,548.58
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,369,451,983.60	640,132,824.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	207,784,463.41	6,018,393.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	881,241,826.00	212,873,890.98
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	280,425,694.19	421,240,540.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,197,401,333.00	2,543,556,929.14
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	2,307,895,732.71
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	2,307,895,732.71

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	2,307,895,732.71
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	2,307,615,732.71
2131124	Өөрийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	280,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	112,064,000.00	235,661,196.43
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	112,064,000.00	43,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	188,161,196.43
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	4,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,085,337,333.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,085,337,333.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,298,240,617.71	(606,805,602.29)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	119,456,590.15	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	247,800.00	-
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	119,208,790.15	-
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(119,456,590.15)	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	2,178,784,027.56	(606,805,602.29)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	14,389,580,600.00	14,537,425,963.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,000.00	14,537,425,963.00
120	Нийтлэг татварын бус орлого	22,000.00	280,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,000.00	280,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,000.00	280,000.00
122	Тусламжийн орлого	-	14,537,145,963.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	14,537,145,963.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	14,537,145,963.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	14,537,145,963.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	14,389,558,600.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	14,389,558,600.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	14,389,558,600.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,255,033,040.00	14,490,812,863.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,255,033,040.00	14,490,812,863.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,057,631,707.00	11,947,255,933.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,421,062,208.51	9,473,202,282.03
210101	Үндсэн цалин	2,706,128,062.55	5,322,039,381.88
210102	Нэмэгдэл	839,095,600.26	2,267,531,546.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	441,134,564.51	1,032,544,193.64

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210104	Урамшуулал	434,703,981.19	851,087,159.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	542,982,525.21	1,042,100,565.56
210201	Тэтгэврийн даатгалын зардал	369,460,827.14	690,108,857.75
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	44,319,655.19	89,302,172.01
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	22,159,828.08	45,598,981.19
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	21,370,357.31	43,418,091.06
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	85,671,857.49	173,672,463.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	185,578,100.00	29,221,500.00
210301	Гэрэл, цахилгаан	22,080,000.00	-
210302	Түлш, халаалт	41,957,100.00	-
210303	Цэвэр, бохир ус	8,153,200.00	-
210304	Байрны түрээс	113,387,800.00	29,221,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	204,530,683.27	94,750,741.69
210401	Бичиг хэрэг	56,783,750.00	18,811,200.00
210402	Тээвэр, шатахуун	30,968,158.00	6,828,008.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	37,220,219.27	53,476,683.69
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	79,558,556.00	15,634,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	446,356,510.01	35,124,350.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	56,109,143.00	3,490,100.00
210602	Тавилга	13,635,200.00	-
210604	Урсгал засвар	376,612,167.01	31,634,250.00
2107	Томилолт, зочны зардал	810,097,147.00	179,254,928.00
210701	Гадаад албан томилолт	599,361,142.00	39,869,928.00
210702	Дотоод албан томилолт	210,736,005.00	139,385,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,220,082,507.00	890,018,455.58
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	927,730,117.00	721,883,158.00
210803	Даатгалын үйлчилгээ	666,252.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	726,796.00	2,022,444.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	290,838,342.00	166,112,853.58
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,226,942,026.00	203,583,111.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	329,562,200.00	6,018,393.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	897,379,826.00	197,564,718.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,197,401,333.00	2,543,556,929.14
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	2,307,895,732.71
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	2,307,895,732.71
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	2,307,895,732.71
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	2,307,615,732.71
2131122	Төсвийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	280,000.00

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	112,064,000.00	235,661,196.43
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	112,064,000.00	43,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	188,161,196.43
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	4,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,085,337,333.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,085,337,333.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,134,547,560.00	46,613,100.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,134,547,560.00	46,613,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,134,547,560.00	46,613,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,134,547,560.00	46,613,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,134,547,560.00	46,613,100.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,134,547,560.00)	(46,613,100.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			2,178,784,027.56	2,178,784,027.56
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			16,475,163.08	16,475,163.08
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			2,195,259,190.64	2,195,259,190.64
19	Тайлант үеийн үр дүн			(606,805,602.29)	(606,805,602.29)
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			1,588,453,588.35	1,588,453,588.35

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	14,778,683,400.00	12,229,530,230.29	2,549,153,169.71	82.75
Татварын бус орлого	14,778,683,400.00	12,229,530,230.29	2,549,153,169.71	82.75
Тусламжийн орлого	14,778,683,400.00	12,229,530,230.29	2,549,153,169.71	82.75
Төсвөөс санхүүжих	14,778,683,400.00	12,229,530,230.29	2,549,153,169.71	82.75
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,778,683,400.00	12,229,530,230.29	2,549,153,169.71	82.75
УРСГАЛ ЗАРДАЛ	14,778,683,400.00	12,229,530,230.29	2,549,153,169.71	82.75
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,494,334,700.00	11,993,869,033.86	2,500,465,666.14	82.75
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,383,213,800.00	9,473,202,282.03	1,910,011,517.97	83.22
Үндсэн цалин	5,986,645,600.00	5,322,039,381.88	664,606,218.12	88.90
Нэмэгдэл	3,457,129,300.00	2,267,531,546.95	1,189,597,753.05	65.59
Унаа хоолны хөнгөлөлт	1,035,087,100.00	1,032,544,193.64	2,542,906.36	99.75
Урамшуулал	904,351,800.00	851,087,159.56	53,264,640.44	94.11
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,467,075,200.00	1,042,100,565.56	424,974,634.44	71.03
Тэтгэврийн даатгал	997,506,800.00	690,108,857.75	307,397,942.25	69.18
Тэтгэмжийн даатгал	117,454,700.00	89,302,172.01	28,152,527.99	76.03
ҮОМШӨ-ний даатгал	58,762,200.00	45,598,981.19	13,163,218.81	77.60
Ажилгүйдлийн даатгал	58,670,400.00	43,418,091.06	15,252,308.94	74.00
Эрүүл мэндийн даатгал	234,681,100.00	173,672,463.55	61,008,636.45	74.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,769,500.00	29,221,500.00	548,000.00	98.16
Байрны түрээс	29,769,500.00	29,221,500.00	548,000.00	98.16
Хангамж, бараа материалын зардал	151,140,300.00	94,750,741.69	56,389,558.31	62.69
Бичиг хэрэг	33,737,300.00	18,811,200.00	14,926,100.00	55.76
Тээвэр, шатахуун	9,335,200.00	6,828,008.00	2,507,192.00	73.14
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	78,245,800.00	53,476,683.69	24,769,116.31	68.34
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	29,822,000.00	15,634,850.00	14,187,150.00	52.43
Эд хогшил, урсгал засварын зардал	139,454,600.00	81,737,450.00	57,717,150.00	58.61
Багаж, техник, хэрэгсэл	107,388,500.00	50,103,200.00	57,285,300.00	46.66
Урсгал засвар	32,066,100.00	31,634,250.00	431,850.00	98.65
Томилолт, зочны зардал	179,294,800.00	179,254,928.00	39,872.00	99.98
Гадаад албан томилолт	39,870,000.00	39,869,928.00	72.00	100.00
Дотоод албан томилолт	139,424,800.00	139,385,000.00	39,800.00	99.97
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	940,802,600.00	890,018,455.58	50,784,144.42	94.60
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	772,221,000.00	721,883,158.00	50,337,842.00	93.48
Даатгалын үйлчилгээ	905,800.00	-	905,800.00	-
Тээврийн хэрэгслийн татвар	2,023,400.00	2,022,444.00	956.00	99.95
Тээврийн хэрэгслийн оношилгоо	142,900.00	-	142,900.00	-

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Мэдээлэл, технологийн үйлчилгээ	164,550,500.00	166,112,853.58	(1,562,353.58)	100.95
Газрын төлбөр	959,000.00	-	959,000.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	203,583,900.00	203,583,111.00	789.00	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	6,019,100.00	6,018,393.00	707.00	99.99
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	197,564,800.00	197,564,718.00	82.00	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	284,348,700.00	235,661,196.43	48,687,503.57	82.88
Бусад урсгал шилжүүлэг	284,348,700.00	235,661,196.43	48,687,503.57	82.88
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	43,500,000.00	43,500,000.00	-	100.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	231,588,700.00	188,161,196.43	43,427,503.57	81.25
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,260,000.00	4,000,000.00	5,260,000.00	43.20
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-	-	-
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-	-	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	264.00	275.00	(11.00)	104.17
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
АЖИЛЛАГСДЫН ТОО	136.00	136.00	-	100.00
Удирдах ажилтан	26.00	9.00	17.00	34.62
Гүйцэтгэх ажилтан	106.00	103.00	3.00	97.17
Үйлчлэх ажилтан	4.00	24.00	(20.00)	600.00
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	125.00	136.00	(11.00)	108.80
Ажлын албаны албан хаагч (АА)	122.00	112.00	10.00	91.80
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3.00	24.00	(21.00)	800.00
НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	2.00	2.00	-	100.00
Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	2.00	2.00	-	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар нь эрхэм зорилгоо “Засгийн газраас харьяа байгууллага, албан тушаалтанд тавих хяналтыг хэрэгжүүлэх, Монгол Улсын Засгийн газрын оновчтой, үр ашигтай засаглалыг бэхжүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Тус газар нь үйл ажиллагааны эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан стратегийн зорилтыг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, тэдгээрийн албан тушаалтан, улсын төсөвт үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, захирамж, хуралдааны тэмдэглэлийг болон албаны чиг үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагаанд холбогдох хуульд заасны дагуу хяналт тавих, байгууллагын дотоод хяналтын нэгж, ажилтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;
- Байгууллага, албан тушаалтны хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлан, мэдээлэл ирүүлэх, явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах, санал, дүгнэлтийг Засгийн газарт танилцуулах;
- Засгийн газрын харьяа байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгчийн сэтгэл ханамж, авлига, хүнд суртлын индекс, олон нийтийн санаа бодол, өргөдөл, гомдлын шинж байдал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, хяналт шалгалт, хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд тандалт судалгаа хийх, дүн шинжлэх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, төрийн байгууллагад процессын дахин инженерчлэл хийх, сайн засаглалыг бэхжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах талаар зөвлөмж хүргүүлэх, хуулиар харьяалуулсан чиг үүрэгтэй холбоотой хууль тогтоомжийн төсөл боловсруулах, эдгээр асуудлаар удирдлагыг зөвлөгөө, арга зүй, мэдээлэл, лавлагаагаар хангах, санал, зөвлөмж боловсруулах;
- Байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд тавих хяналтын хүрээнд мэдээллийн системийн шинжилгээ хийх, үр ашигтай, бүтээмжтэй системийг хөгжүүлэх, аюулгүй байдлыг хангах, хамгаалах талаар санал, зөвлөмж өгөх, хяналтын нэгдсэн системийг хөгжүүлэх, удирдах;
- Хяналт хэрэгжүүлэх газрын төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэх, төсөв, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, санхүүгийн үйл ажиллагааг зохион байгуулж албан тушаалтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ёс зүйн болон бусад зөрчил дутагдал, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтад хамруулах, эсхүл эрх бүхий байгууллага, албан тушаалтанд энэ талаар санал, албан шаардлага хүргүүлж, биелэлтийг шаардах үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- Хяналт хэрэгжүүлэх газрын үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомж, бодлого, шийдвэр, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явц, үр нөлөө, зорилгод хүрч байгаа байдал болон зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланд хяналт-шинжилгээ хийх, зөвлөмж, санал өгч санхүүгийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар нь Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий хяналт хэрэгжүүлэх төрийн захиргааны байгууллага юм.

Үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газар дахь хяналтын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль,

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Татварын ерөнхий хууль тогтоомжууд, Сангийн сайдын холбогдох журам, заавруудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар нь тайлант онд Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад шилжин ирсэн байна. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон Сангийн сайдын холбогдох журам зааварт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Тайлант онд Дотоод хяналт, аудитын газраас 2025 оны дотоод хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөний дагуу тус газрын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлан болон үйл ажиллагаанд дотоод аудитыг гүйцэтгэж, 5 зөвлөмж өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/113 тоот тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 102,061.9 мянган төгрөгөөр буюу 4.68 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	76,809.6	17,500.9	(59,308.7)
Урьдчилгаа	111,308.3	73,382.0	(37,926.3)

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бараа материал	238,190.4	222,639.2	(15,551.2)
Үндсэн хөрөнгө	1,752,475.7	1,763,200.0	10,724.3
Нийт хөрөнгө	2,178,784.0	2,076,722.1	(102,061.9)
Өр төлбөр	-	488,268.5	488,268.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,178,784.0	1,588,453.6	(590,330.4)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,178,784.0	2,076,722.1	(102,061.9)

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансдууд байна. Тухайлбал,

Авлага дансны үлдэгдэл 17,500.9 мянган төгрөгийн 17,385.6 мянган төгрөг нь он дамнан ээлжийн амралтаа авсан 6 албан хаагчдад урьдчилж олгосон ээлжийн амралтын цалин байна. Өмнөх онд үүссэн байгууллагаас авах 73,142.1 мянган төгрөгийн авлага тайлант онд барагдсан байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 73,382.0 мянган төгрөг нь нэг жилийн хугацаатай лиценз, үйлчилгээний төлбөрийн тайлант онд ногдохгүй зардлыг урьдчилж гарсан зардлаар бүртгэсэнтэй холбоотой байна. Өмнөх онд үүссэн томилолтын урьдчилгаа 111,308.3 мянган төгрөгийн 91,328.3 мянган төгрөгийг Солонгос, Малайз Улсад ажилласан гадаад албан томилолт, 19,980.0 мянган төгрөгийг Булган, Сэлэнгэ аймагт ажилласан дотоод албан томилолтын зардлаар тус тус тайлагнаж, урьдчилж гарсан зардлыг тайлант онд хүлээн зөвшөөрсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 222,639.2 мянган төгрөг болж өмнөх оноос 15,551.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 25,798.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 41,350.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 10,724.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд нэмэгдсэн хөрөнгө 432,270.2 мянган төгрөг, тайлант оны элэгдлийн зардал 421,240.5 мянган төгрөг, шилжүүлэн авсан хөрөнгийн 16,780.6 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан элэгдлийн 16,475.2 мянган төгрөгийн залруулгын зөрүү байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 279,878.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, ТӨБЗГ-ын 2025 оны 475 дугаар тогтоолын дагуу 152,392.2 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авсан байна.

Байгууллагын биет бус хөрөнгөд 93,922.7 мянган төгрөгийн галт хана, санхүүгийн болон хяналт шалгалтын программ, 241,000.0 мянган төгрөгийн 3 газар бүртгэлтэй байна. Санхүүгийн тайланд бүртгэлтэй 3 газрын эзэмших эрхийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 01110-А/1863/2025, 2026 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн А/25, 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/114 дүгээр захирамжаар тус тус шилжүүлэн авсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 488,268.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн төсөлд тусгаагүй 489,039.6 мянган төгрөг, үр ашиггүй 230,923.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож төсвийг зохистой удирдаагүйгээс худалдан авсан бараа, үйлчилгээний төлбөрийг төлөөгүйтэй холбоотой байна. Нийт өр төлбөрийн 218,424.9 мянган төгрөг нь тайлант онд худалдан авсан компьютер, тоног, төхөөрөмж, 250,747.8 мянган төгрөг нь байрны түрээсийн төлбөртэй холбоотой байгууллагад төлөх өглөг байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,588,453.6 мянган төгрөг болж буурсан нь тайлант оны үр дүн 590,330.4 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 23,590,969.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн 01/361 тоот албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна.

Төсвийн төсөлд төсөвлөсөн дүнгээс материаллаг өөрчлөлт гарсан зардлын үзүүлэлтийг дурдвал цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 785,658.5 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлыг 173,400.9 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 156,065.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 124,454.7 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг зардлыг 162,201.4 мянган төгрөг, хөрөнгийн зардлыг 4,816,105.4 мянган төгрөгөөр тус тус бууруулж 2025 оны төсвийг 19,291,228.9 мянган төгрөгөөр баталсан нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

Төсвийн захирагчийн тайлант оны батлагдсан төсвийг 4,512,545.5 мянган төгрөгөөр бууруулж, 14,778,683.4 мянган төгрөг болгон тодотгосон байна. Үүнд:

Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 904,966.5 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 88,361.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,719.6 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 65,008.9 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 907,902.4 мянган төгрөг, томилт, зочны зардлыг 340,016.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 847,355.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 630,860.0 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийг 726,355.6 мянган төгрөгөөр тус тус бууруулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 14,778,683.4 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 14,537,426.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, 12,229,530.2 мянган төгрөгийг зарцуулж, 2,307,895.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 12,229,530.2 мянган төгрөг буюу 82.75 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 1,910,011.5 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 424,974.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардлыг 548.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 56,389.6 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 57,717.2 мянган төгрөг, томилт, зочны зардлыг 39.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 50,784.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.8 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 48,687.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Код	Нэр				
70103	Гүйцэтгэх засаглалын удирдлага	14,778,683.4	12,229,530.2	2,549,153.2	82.75
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	13,722,113.7	11,271,985.9	2,450,127.8	82.14
80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	250,000.0	249,800.0	200.0	99.92
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	213,508.0	178,100.1	35,407.9	83.42

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	284,348.7	235,661.2	48,687.6	82.88
81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	308,713.0	293,983.0	14,730.0	95.23

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 474 дүгээр тогтоолоор Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын орон тооны дээд хязгаарыг 150 байхаар тогтоосон байна. Тайлант онд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 02 дугаар сарын 03-ний өдрийн А/18, даргын 2025 оны 09 дүгээр сарын 10-ний өдрийн А/125 дугаар тушаалаар тус газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчилж, орон тоог 150 байхаар баталжээ. Орон тооны цомхотгол хийгдээгүй боловч тус газар нь 2025 онд 120-138 орон тооны гүйцэтгэлтэй ажилласан байна.

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/165 дугаар тушаалаар тус газрын албан хаагчдын хоолны зардлыг ажлын нэг өдөрт 34.0 мянган төгрөг, унааны зардлыг 3.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна.

Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлого, гарын авлагын төслийг танилцуулах хэлэлцүүлэг зохион байгуулахад 28,514.2 мянган төгрөг, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын байгууллагын бүтэц, дүрмийн шинэчлэлийг танилцуулах болон алсын хараа, стратегийн зорилго, зорилтын төслийг танилцуулах хэлэлцүүлэг зохион байгуулахад 34,232.0 мянган төгрөгийг тус тус төсөвлөн гүйцэтгэсэн байна.

Гадаад албан томилолтын зардалд 36,284.4 мянган төгрөг төлөвлөж, Бүгд Найрамдах Франц Улс болон Испанийн Хаант Улсын Аудитын шүүх байгууллагуудын урилгаар тус байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах, хамтын ажиллагаа тогтоох, туршлага судлах чиглэлээр албан томилолтоор ажилласан байна.

Видео контент, фото мэдээ бэлтгэж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээх үйлчилгээний гэрээг 26 хуулийн этгээдтэй байгуулж, нийт 249,800.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2025 оны А/11, нэмэлт А/56, А/149 дүгээр тушаалаар тус газрын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн баталж, нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 218,050.0 мянган төгрөг, харьцуулалтын аргаар 75,000.0 мянган төгрөг, шууд худалдан авалтын аргаар 417,700.0 мянган төгрөг нийт 710,750.0 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 621,431.9 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдаж авснаас нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 217,424.9 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж, харьцуулалтын аргаар 68,383.0 мянган төгрөгийн программ хангамжийн лиценз, шууд худалдан авалтаар 335,624.0 мянган төгрөгийн бараа, үйлчилгээ худалдан бэлтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үндсэн хөрөнгө, бараа материал, урсгал зардал, худалдан авах ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын аудитор Г.Тэлмүүн, ахлах аудитор Д.Мөнхжин нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01/120 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Их” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 13,293,415.4 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 66,467.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 37,510.6 мянган төгрөгийн зөрчил илэрч зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 2 зөрчилд 2 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш орлогын 14,784,885.3 мянган төгрөгийн 36 гүйлгээ, зарлагын 1,037,503.9 мянган төгрөгийн 90 гүйлгээг шилэн дансны цахим системд бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт 1: Ажилчдын ашиглаж буй зарим хөрөнгүүд нь марк загвараар коджуулсан тэмдэглэгээ бүхий наалтгүйгээс бүртгэлээрх нэр төрлийн хөрөнгийг эд хариуцагчийн карт руу тулгах боломжгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилчдын ашиглаж буй хөрөнгүүдийг бүрэн марк, загвараар коджуулж ажиллах зөвлөмж өгөв.

Илрүүлэлт 2: Худалдан авах ажиллагааг тендер шалгаруулалтын харьцуулалтын аргаар үнийн санал дуудаж зохион байгуулахдаа хүчингүй болсон тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийг ашигласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална.", Сангийн сайдын 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн А/106 дугаар тушаалтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хүчин төгөлдөр тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийг ашиглаж байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн бөгөөд бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитад байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, урсгал зардал, нэмэлт санхүүжилтийн данснуудын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Завсрын аудитаар илрүүлсэн 1,397.024.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил бүхий асуудлын, бүртгэлийг боловсруулж, 2 төлбөрийн акт, 2 хариуцлага тооцох албан шаардлага, 5 албан шаардлага, 5 зөвлөмжийг жилийн эцсийн аудитад нэгтгэсэн болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн зөрчлийг таслан зогсоох 1,356,694.1 мянган төгрөгийн 7 албан шаардлагын биелэлт 8.5 хувьтай, алдааг засах 3 зөвлөмжийн биелэлт 66.6 хувьтай, нийт шийдвэрийн хэрэгжилт 42.9 хувьтай байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	7	1,356,694.1	3	114,648.6	42.9
Зөвлөмж	3	-	2	-	66.6
Нийт дүн	10	1,356,694.1	5	114,648.6	42.9

Өмнөх аудитаар өгсөн Худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөөгүй, бараа, ажил, үйлчилгээний төсөв өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын зохих аргыг хэрэглээгүй, шууд худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоох, гэрээт ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй зөрчлийг таслан зогсоох, төрийн хэмнэлтийн тухай хуулийн хориглох заалтыг хэрэгжүүлээгүй, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулаагүй зөрчлийг таслан зогсоох, "Худалдан авах ажиллагааны журмыг буруу сонгосон, гэрээний үүргийн хэрэгжилтийг дүгнээгүй, нягтлан бодох бүртгэлийг аккруэл сууриар бүртгээгүй зөрчлийг

таслан зогсоох 4 албан шаардлага, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тэмдэглэл, урсгал төсвийн болон нэмэлт санхүүжилтийн тайлан, төсвийн тохируулгын тайланг холбогдох хууль, тогтоомжийн дагуу иж бүрэн бэлтгэн, толилуулж байх 1 зөвлөмжийг өгсөн боловч тайлант онд хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, зөрчил давтагдан гарсан тул албан шаардлага хүргүүлж, хариуцлага тооцуулахаар шийдвэрлэсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар нь тайлант онд Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад шилжин ирсэнтэй холбоотойгоор сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаандаа ашиглах нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж эхлээд байна. Дараагийн аудитаар шинээр худалдан авсан үндсэн хөрөнгүүдийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан ашиглах жилээр бүртгэж байгаа эсэх.
- Байгууллагын ашигладаг санхүүгийн программ нь Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бүрэн шинэчлэл хийгдсэн эсэх
- Түүнчлэн, Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал", "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар", "Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал"-ыг төсвийн гүйцэтгэл, тайлагналдаа хэрэгжүүлж ажилласан эсэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,140,456.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 3,140,456.2 мянган төгрөгийн алдааг бүрэн залрууллаа.

Залруулсан алдаа:

- Улсын төсвийн орлогод төвлөрүүлсэн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 2,307,895.7 мянган төгрөгийг Мөнгөн гүйлгээний тайлан, Үр дүнгийн тайлангаас цэвэрлэж тайлагнасан;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд Сангийн яамтай нийлсэн урсгал зардлын тооцооноос нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 346,233.4 мянган төгрөгөөр дутуу, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,409.5 мянган төгрөгөөр илүү дүнгээр тайлагнасан;
- Мөнгөн гүйлгээний тайланд нийт 286,533.3 мянган төгрөгийн хасах дүнтэй орлого тайлагнасан;
- Мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг 86,555.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
- Нэг жилийн хугацаатай программ хангамж, лицензийн төлбөрийн тайлант онд ногдохгүй зардлыг урьдчилж гарсан зардлаар бүртгээгүй шууд зардлаар хүлээн зөвшөөрсөн;
- Өмнөх онд урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн гадаад албан томилолтын 91,928.3 мянган төгрөгийн зардлаас 38,446.7 мянган төгрөгийг ор дүнгийн тайланд дотоод албан томилолтын зардлаар ангилал зөрүүлж тайлагнасан.

Залруулсан алдаа: УСНББОУС-1-ийн 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг”, санхүүгийн тайлангийн толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй тул алдааг аудитын явцад бүрэн залрууллаа.

Аудитаар нийт 2,555,020.3 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 18,942.8 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,219,932.5 мянган төгрөгийн зөрчилд 10 албан шаардлага 419,214.0 мянган төгрөгийн 2 зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлаг хүргүүлж, 896,931.0 мянган төгрөгийн 6 зөрчилд зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй 2,555,020.3 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2,488,553.2 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны А/05 дугаар тушаалаар тус газрын дарга өөрийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргаж, 8,535.0 мянган төгрөгийн нэмэгдэл цалин авсан байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхоыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргаж, нэмэгдэл цалин авсан 8,535.0 мянган төгрөгийн зөрүү төлбөрийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

Илрүүлэлт 2: Үндсэн хөрөнгийн түүвэр тооллого хийхэд 6,538.2 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй Lenovo брэндийн Yogabook-9 загварын нөүтбүүк биетээр оршин байхгүй байна. Түүнчлэн, байгууллагын эд хөрөнгийн тооллогын комиссын дүгнэлтээр 3,869.6 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй Ipad 13 pro загварын таблет дутсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн 10,407.8 мянган төгрөгийн төлбөрийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

1. Санхүүгийн тайлантай холбоотой

Илрүүлэлт 1: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн тодруулга, Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга, төсвийн тохирууллагын тайланг иж бүрэн бэлтгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4-т "Санхүүгийн нэгтгэсэн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 54.4.5-д "санхүүгийн тайлангийн тодруулга", 54.5-д "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна", 54.5.4 "хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар "Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тэмдэглэл, урсгал төсвийн болон нэмэлт санхүүжилтийн тайлан, төсвийн тохируулгын тайланг холбогдох хууль, тогтоомжийн дагуу иж бүрэн бэлтгэн, толилуулж байх" зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

2. Өр төлбөр үүсгэсэнтэй холбоотой

Илрүүлэлт 1: Төсвийн төсөлд тусгаагүй 489,039.6 мянган төгрөг, үр ашиггүй 197,880.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож төсвийг зохистой удирдаагүйгээс 488,268.5 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;”, гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн төсөлд тусгаж, батлагдаагүй ажил үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулж, өр төлбөр үүсгэсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

3. Цалин, урамшуулалтай холбоотой

Илрүүлэлт 1: Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 10-р зүйлд заасан үндэслэлээр, 17-р зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхээр 2 ажлын хэсэг байгуулагдаж, өөрийн үндсэн чиг үүргийн ажил гүйцэтгэснийг онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн гэж үзэн ажлын хэсгийн гишүүдэд нийт 110,646.0 мянган төгрөгийн урамшуулалыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон боловч онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн эсэхийг үнэлсэн шалгуур, үнэлгээний тайлан, хурлын тэмдэглэл байхгүй байна. Үүнд:

- "Өргөдөл, гомдлын бүртгэл, ангилал, шийдвэрлэлтийг нэгдсэн байдлаар хянаж, давхардлыг тогтоон, дүн шинжилгээ хийх..." ажлын хэсгийн 8 албан хаагчид 27,947.0 мянган төгрөг;
- "Экспортыг нэмэгдүүлж, худалдааг дэмжих" ажлын хэсгийн 24 албан хаагчид 82,699.0 мянган төгрөгийн урамшууллыг тус тус олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4-р зүйлийн 4.1.3-т "үр ашигтай байх; 4.2.2-т "хэмнэлтийн горим нь иргэд, олон нийтийн ашиг сонирхолд нийцэж, тэдний дэмжлэгийг хүлээхүйц түвшинд тодорхойлогдсон байх", Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2 дугаар зүйлийн 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна.", Төрийн албан хаагчид шагнал олгох журмын 3 дугаар зүйлийн 3.3-т "Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн эсэхийг үнэлсэн шалгуур, үнэлгээний тайлан, хурлын тэмдэглэл байхгүй урамшуулалыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Илрүүлэлт 2: ЗГХХГ-ын 9 албан хаагч Зургаан сараас дээш хугацаагаар түр орлон гүйцэтгэсэн тохиолдолд тус албан тушаалын цалингийн 40.0 хүртэлх хувиар түр орлон гүйцэтгүүлсэний нэмэгдэл цалин олгохоор байгаа боловч тус 9 албан хаагчид эхний сараас 24,896.8 мянган төгрөгийн 40.0 хувийн нэмэгдэл цалин олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5-д "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална", Монгол улсын засгийн газрын 2019 оны 09 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журмын 2.2-т "Энэ журмын 2.1-д заасан түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн ажлаас гадна нэмэлт албан үүргийг түр орлон гүйцэтгэж холбогдох журамтай нийцээгүй нэмэлт цалин авсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Илрүүлэлт 3: Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны А/05 дугаар тушаалын хавсралтад дурдсан ахлах хянан шалгагч

болон хянан шалгагчид төсөвт батлагдаагүй, нийт 144,811.2 мянган төгрөгийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл цалинг үндсэн цалингийн сангаас тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16-р зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох",

Шийдвэрлэсэн нь: Төсөвт батлагдаагүй, хянан шалгагчид 40 хүртэлх хувийн нэмэгдэл цалин олгосон зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

4. Урсгал зардалтай холбоотой

Илрүүлэлт 1: Төсвийн төсөлд тусгаж, батлуулаагүй нийт 239,239.6 мянган төгрөгийн үр ашиггүй, зориулалт бус зарцуулалт санхүүжүүлсэн байна. Үүнд:

- "Эко интэрнейшл тауэр" барилгад оффисын 504.9 м.кв талбайн түрээс болон байр ашиглалтын зардалд 196,794.6 мянган төгрөг;
- Байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ дотоод хүний нөөцийг ашиглалгүйгээр нийт 33,700.0 мянган төгрөгийн судалгааны ажлыг хувь хүн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлсэн;
- "Газрын эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал" хэлэлцүүлгийн катеринг үйлчилгээнд 1,595.0 мянган төгрөг;
- Монгол Улсын байгаль орчны салбарт тулгамдаж буй асуудал уулзалтыг зохион байгуулахад 7,150.0 мянган төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт батлагдаагүй, үр ашиггүй зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Илрүүлэлт 2: Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамтай нийцээгүй мөнгөн тусламжийг олгосон дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2025 оны А/01 дүгээр тушаалаар Хөдөлмөрийн дотоод журамд заасан магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллагын оношоор 2 сараас дээш хугацаагаар эмчилгээ хийлгэж байгаа тохиолдолд албан хаагчид 5,000.0 мянган төгрөгийн мөнгөн тусламж олгохоор заасан боловч 1 албан хаагчид 18,000.0 мянган төгрөгийн тусламж олгосон;
- Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2025 оны А/13 дугаар тушаалаар Хуулийн багийн гэрээт зөвлөхөд Хөдөлмөрийн дотоод журамд заасан 3,000.0 мянган төгрөгийн нэг удаагийн тусламж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16-р зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно.", 61 дүгээр зүйлийн 61.1-д "Төрийн албан хаагч дараах нийтлэг баталгаагаар хангагдана", 61.1.1-д "албан тушаалын цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал, урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж авах", Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д "Хамтын гэрээгээр зохицуулах харилцааг талууд харилцан тохиролцох бөгөөд ажилтны хөдөлмөрлөх эрх, хууль ёсны ашиг сонирхолтой холбоотой дараах асуудлыг хамтын гэрээнд тусгаж болно", 37.1.3-т "ажил олгогчоос

ажилтанд олгох тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийн хэмжээ", ЗГХХГ-ын даргын 2024 оны А/159 дүгээр тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журмын 12.1.2-т "Магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллагын оношоор Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтран баталсан "Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох баримтлах өвчний жагсаалт"-д орсон өвчний учир 2 сараас дээш хугацаагаар эмчилгээ хийлгэж байгаа тохиолдолд албан хаагчид 5,000,000 (таван сая) хүртэл төгрөгийн мөнгөн тусламж;" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасан мөнгөн тусламжийг хэтрүүлэн олгосон зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Илрүүлэлт 3: Судалгааны ажил хийлгэх худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ижил төстэй байдлаар нь багцлаагүй, шууд худалдан авч болох бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарт багтааж Цахим Гэрэгэ ХХК-аар 18,300.0 мянган төгрөг, Нэйшнл судалгаа ХХК-аар 19,900.0 мянган төгрөг, Эй Ай Ложистикс Плас ХХК-аар 18,600.0 мянган төгрөг (үйл ажиллагааны чиглэлд судалгаа хийх чиг үүрэг байхгүй), Эксептед ХХК-аар 19,200.0 мянган төгрөг (үйл ажиллагааны чиглэлд судалгаа хийх чиг үүрэг байхгүй), Энх Алтай Хөгжил Капитал ХХК-аар 18,600.0 мянган төгрөгийн ажил гүйцэтгүүлсэн байна. Тус судалгааны ажлуудыг байгууллагын үйл ажиллагаанд ашиглаагүй, үр ашиггүй зарцуулалт бөгөөд Аж ахуй нэгжийн эцсийн эзэмшигч нар нь харилцан хамааралгүй боловч тайлан нэг ижил хэв маяг, загвараар боловсруулагдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална", 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6 дугаар зүйлийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах;" 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ижил төстэй байдлаар нь багцлаагүй, шууд худалдан авч болох бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарт багтааж, гэрээ байгуулсан бөгөөд хүлээн авсан нэг ижил хэв маяг, загвараар боловсруулсан судалгааны ажлуудыг байгууллагын үйл ажиллагаанд ашиглаагүй, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Илрүүлэлт 4: Хувь хүнтэй 18,200.0 мянган төгрөг, Хөгжлийн хөтөч НҮТББ-тай 19,800.0 мянган төгрөг, Ухаалаг засаглал ТББ-тай 25,870.0 мянган төгрөгийн, нийт 63,870.0 мянган төгрөгийн судалгааны ажил санхүүжүүлсэн боловч байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаагүй, хэрэгцээ шаардлагагүй, үр ашиггүй зарцуулалт гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах;" 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаагүй судалгааны ажилд үр ашиггүй зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Илрүүлэлт 5: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж дараах үр ашиггүй зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Брошур, тараах материал хэвлүүлэхэд 440.0 мянган төгрөг;

- Сургалтын арга хэмжээнд бэлэг дурсгалын зүйл худалдан авахад 1,144.4 мянган төгрөг;
- Байгууллагын бүтэц, дүрмийн шинэчлэлийг танилцуулах арга хэмжээг Тэрэлжид байрлах амралтын газар зохион байгуулахад 32,666.6 мянган төгрөг;
- Арга хэмжээ хөтлөх хөтлөгчийн зардалд 3,000.0 мянган төгрөг;
- Байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авахад 260.0 мянган төгрөг.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4-р зүйлийн 4.1.3-т "үр ашигтай байх; 4.2.2.хэмнэлтийн горим нь иргэд, олон нийтийн ашиг сонирхолд нийцэж, тэдний дэмжлэгийг хүлээхүйц түвшинд тодорхойлогдсон байх", 12-р зүйлийн 12.1.3-т "хэвлэлийн захиалгын төлбөр", 15-р зүйлийн 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", "15.1.7.байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах", 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүйгээс үр ашиггүй зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

5. Албан үүргээ биелүүлээгүйтэй холбоотой

Илрүүлэлт 1: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар нь 2025 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 27-ний өдөр буюу хуулийн хугацаанд ирүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх", 70 дугаар зүйлийн 70.1-д "Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүй, албан үүргээ биелүүлээгүй Хилийн боомтын захиргааны холбогдох буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй дараах асуудлууд байна. Үүнд:

- Бараа, ажил, үйлчилгээг шууд худалдан авах аргаар зохион байгуулахын тулд төсөвт өртгийг хуваасан;
- Өмнөх онд хэрэгжүүлж, санхүүжилтийг олгосон "Процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээ" зөвлөх үйлчилгээний гэрээг дүгнэж акт үйлдээгүй, ажлын тайланг ирүүлээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.
- Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, албан тушаалын жагсаалтад гэрээт шинжээч, судлаач, зөвлөхийн орон тоо батлан, гэрээт ажилтантай шууд Хөдөлмөрийн гэрээ байгуулж, Төрийн албаны цалингийн шатлалын дагуу 419,214.0 мянган төгрөгийг цалингийн сангаас цалинжуулж байна.

Төрийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн үйлчилгээний албан тушаалд төрийн үйлчилгээг адил тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэх болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах чиг үүрэг бүхий хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллах дараах албан тушаал хамаарна", 14.1.1-д "төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаал", 14.1.2-т "боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, урлаг, спорт зэрэг төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын дарга,

захирал, эрхлэгч, бусад удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаал", 14.1.3-т "ям, агентлагийн харьяа болон түүний дэргэд ажилладаг, төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаал", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүй, албан үүргээ биелүүлээгүй буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын бүртгэлийн дансны үлдэгдлийн баталгааг Сангийн яамны Төрийн сангийн мэргэжилтэнтэй тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;", Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ний өдрийн 444 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4.24-т "Энэ журмын 3.4.1, 3.4.2-т заасан албан тушаалтан бүртгэлийн дансны үлдэгдлийн баталгааг мөн журмын 5 дугаар хавсралтад заасан маягтын дагуу" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын бүртгэлийн дансны үлдэгдлийн баталгааг Сангийн яамны Төрийн сангийн мэргэжилтэнтэй тооцоо нийлж, баталгаажуулж байх.

Илрүүлэлт 2: Байгууллагын ашиглаж байгаа санхүүгийн программ нь Сангийн яамнаас нийтэд мэдээлсэн Нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийн жагсаалтад багтаагүй, Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу шинэчлэл хийгдээгүй байна. Ерөнхий журнал болон санхүүгийн тайлан дахь дансны код зөрүүтэй байгаагаас ерөнхий журналын гүйлгээгээр тулгалт хийх, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсанд үндэслэлтэй баталгаа өгөх боломжгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ", 17.1.11-д "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программыг нийтэд мэдээлэх" гэж заасны дагуу Сангийн яамнаас 2025 оны 03 дугаар сарын 08-ний өдөр нийтэд мэдээлсэн Нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийн жагсаалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үйл ажиллагаанд Сангийн яамнаас нийтэд мэдээлсэн Нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийн жагсаалтад багтсан санхүүгийн программ ашиглаж байх.

2. Урсгал зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Эдийн засгийн ангилал зөрчиж 66,619.7 мянган төгрөгийн зардал гаргасан байна. Үүнд:

- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 65,616.9 мянган төгрөгийг байрны түрээсийн зардалд;
- Бараа үйлчилгээний бусад зардлаас 1,002.8 мянган төгрөгийг байр ашиглалтын зардалд.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 22 дугаар зүйлийн 22.9-т "Энэ хуулийн 22.6.8-д заасан ангиллаар тогтоосон төсвийг зүйл хооронд шилжүүлэн зарцуулах эрхийг төсвийн захирагчийн ангилал бүрээр тогтоох, томсгосон хяналтын түвшинг тогтоох нийтлэг журмыг Засгийн газар тогтоон мөрдүүлнэ." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ гаргахгүй байх.

Илрүүлэлт 2: Байгууллагын үндсэн чиг үүрэгт хамааралгүй "Улсын аварга малчин..." шагнал гардуулах дотоод албан томилолтод 5 албан хаагчийг ажиллуулж, 1,900.0 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод албан томилолтын зардлаас байгууллагын үндсэн чиг үүрэгт хамаарах томилолтын зардлыг санхүүжүүлж, томилолтын үр дүнг үнэлж байх.

3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 460,836.3 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, бусад биет бус хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 7 дугаар зүйлд "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэн бүртгэлд тусгах.

4. Цалин, урамшуулалтай холбоотой

Илрүүлэлт 1: ЗГХХГ-ын даргын 2025 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн А/125 дугаар тушаалаар зохион байгуулалтын бүтцийн нэгжийн орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталсантай холбоотойгоор ТАЗ-ийн зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтоос шинэчлэн өөрчлөлт оруулах албан тушаалын тодорхойлолтуудын санал боловсруулж, ТАЗ-д хүргүүлсэн байна. Түүнчлэн, ЗГХХГ-ын даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/198 дугаар тушаалаар тус байгууллагын ТҮ-ний албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталсан байна. ТАЗ-өөс зөвшөөрөл олгоогүй, ТҮ-ний албан тушаалын тодорхойлолт шинэчлэн батлагдаагүй байхад ЗГХХГ-ын даргын 2025 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн А/125 дугаар тушаалаар шинэчилсэн бүтцээр албан хаагчдыг томилон ажиллуулж байна.

Энэ нь Төрийн албаны зөвлөлийн 2019 оны "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай" 03 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.5-д "Төрийн албаны зөвлөл нь албан тушаалын тодорхойлолтыг хянан, хуудас бүр дээр Төрийн албаны зөвлөлийн тэмдэг дарна.", 6 дугаар зүйлийн 6.2-т "Байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан нь тухайн албан тушаалын тодорхойлолтыг албан тушаалд томилогдож буй этгээдэд албан ёсоор танилцуулах үүрэгтэй бөгөөд танилцсан тухай баримтад гарын үсэг зуруулж, хувийн хэрэгт хавсаргана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Өгсөн зөвлөмж: Төрийн албаны зөвлөлөөс зөвшөөрөл олгосон бүтцээр албан хаагчдыг томилон ажиллуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Мөнгөн гүйлгээний тайланд Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг 86,555.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.	1	86,555.6			1	86,555.6	1	86,555.6				
Мөнгөн гүйлгээний тайланд нийт 286,533.3 мянган төгрөгийн хасах дүнтэй орлого тайлагнасан байна.	1	286,533.3			1	286,533.3	1	286,533.3				
Нэг жилийн хугацаатай программ хангамж, лицензийн төлбөрийн тайлант онд ногдохгүй зардлыг урьдчилж гарсан зардлаар бүртгээгүй шууд зардлаар хүлээн зөвшөөрсөн байна.	1	73,382.0	1	73,382.0			1	73,382.0				
Өмнөх онд урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн гадаад албан томилолтын 91,928.3 мянган төгрөгийн зардлаас 38,446.7 мянган төгрөгийг Үр дүнгийн тайланд дотоод албан томилолтын зардлаар ангилал зөрүүлж тайлагнасан байна.	1	38,446.8			1	38,446.8	1	38,446.8				

Төсвийн гүйцэтгэлийн тайланд Сангийн яамтай нийлсэн урсгал зардлын тооцооноос нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 346,233.4 мянган төгрөгөөр дутуу, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,409.5 мянган төгрөгөөр илүү дүнгээр тайлагнасан байна.	1	347,642.8			1	347,642.8	1	347,642.8				
Улсын төсвийн орлогод төвлөрүүлсэн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 2,307,895.7 мянган төгрөгийг Мөнгөн гүйлгээний тайлан, Үр дүнгийн тайлангаас цэвэрлэж тайлагнасан байна.	1	2,307,895.7	1	2,307,895.7			1	2,307,895.7				
Нийт дүн	6	3,140,456.2	2	2,381,277.7	4	759,178.5	6	3,140,456.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗГХХГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны А/05 дугаар тушаалаар тус газрын дарга өөрийн	1	8,535.0	1	8,535.0								

хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргаж, нэмэгдэл цалин авсан байна.												
Үндсэн хөрөнгийн түүвэр тооллого хийхэд 6,538.2 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй Lenovo брэндийн Yogabook-9 загварын нөүтбүүк биетээр оршин байхгүй байна. Түүнчлэн, байгууллагын эд хөрөнгийн тооллогын комиссын дүгнэлтээр 3,869.5 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй Ipad 13 pro загварын таблет дутсан байна.	1	10,407.8	1	10,407.8								
Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамтай нийцээгүй мөнгөн тусламжийг олгосон дараах зөрчил илэрлээ. Үүнд: <ul style="list-style-type: none"> Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2025 оны А/01 дүгээр тушаалаар Хөдөлмөрийн дотоод журамд заасан магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн 	1	16,000.0			1	16,000.0						

<p>байгууллагын оношоор 2 сараас дээш хугацаагаар эмчилгээ хийлгэж байгаа тохиолдолд албан хаагчид 5,000.0 мянган төгрөгийн мөнгөн тусламж олгохоор заасан боловч 1 албан хаагчид 18,000.0 мянган төгрөгийн тусламж олгосон;</p> <ul style="list-style-type: none"> Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2025 оны А/13 дугаар тушаалаар Хуулийн багийн гэрээт зөвлөхөд Хөдөлмөрийн дотоод журамд заасан 3,000.0 мянган төгрөгийн нэг удаагийн тусламж олгосон байна. 												
<p>Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 10-р зүйлд заасан үндэслэлээр, 17-р зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхээр 2 ажлын хэсэг байгуулагдаж, өөрийн үндсэн чиг үүргийн ажил гүйцэтгэснийг онцгой чухал буюу онц түвэгтэй</p>	1	110,646.0			1	110,646.0						

<p>албан даалгавар биелүүлсэн гэж үзэн ажлын хэсгийн гишүүдэд нийт 110,646.0 мянган төгрөгийн урамшуулалыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон боловч онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн эсэхийг үнэлсэн шалгуур, үнэлгээний тайлан, хурлын тэмдэглэл байхгүй байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • "Өргөдөл, гомдлын бүртгэл, ангилал, шийдвэрлэлтийг нэгдсэн байдлаар хянаж, давхардлыг тогтоон, дүн шинжилгээ хийх..." ажлын хэсгийн 8 албан хаагчид 27,947.0 мянган төгрөг; • "Экспортыг нэмэгдүүлж, худалдааг дэмжих" ажлын хэсгийн 24 албан хаагчид 82,699.0 мянган төгрөгийн урамшууллыг тус 														
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

тус олгосон байна.												
Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны А/05 дугаар тушаалын хавсралтад дурдсан ахлах хянан шалгагч болон хянан шалгагчид төсөвт батлагдаагүй, нийт 144,811.2 мянган төгрөгийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл цалинг үндсэн цалингийн сангаас тооцож олгосон байна.	1	144,811.2			1	144,811.2						
ЗГХХГ-ын 9 албан хаагч Зургаан сараас дээш хугацаагаар түр орлон гүйцэтгэсэн тохиолдолд тус албан тушаалын цалингийн 40.0 хүртэлх хувиар түр орлон гүйцэтгүүлсэний нэмэгдэл цалин олгохоор байгаа боловч тус 9 албан хаагчид эхний сараас 24,896.8 мянган төгрөгийн 40.0 хувийн нэмэгдэл цалин олгосон байна.	1	24,986.8			1	24,986.8						
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн тодруулга,	1	-			1	-						

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга, төсвийн тохирууллагын тайланг иж бүрэн бэлтгээгүй байна.												
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж дараах үр ашиггүй зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд: - Брошур, тараах материал хэвлүүлэхэд 440.0 мянган төгрөг; - Сургалтын арга хэмжээнд бэлэг дурсгалын зүйл худалдан авахад 1,144.4 мянган төгрөг; - Байгууллагын бүтэц, дүрмийн шинэчлэлийг танилцуулах арга хэмжээг Тэрэлжид байрлах амралтын газар зохион байгуулахад 32,666.6 мянган төгрөг; - Арга хэмжээ хөтлөх хөтлөгчийн зардалд 3,000.0 мянган төгрөг; - Байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авахад 260.0 мянган төгрөг.	1	37,510.6			1	37,510.6						
Төсвийн төсөлд тусгаагүй 489,039.6 мянган төгрөг, үр ашиггүй 197,880.6	1	488,268.5			1	488,268.5						

<p>мянган төгрөгийн санхүүжилт олгож төсвийг зохистой удирдаагүйгээс 488,268.5 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.</p>												
<p>Төсвийн төсөлд тусгаж, батлуулаагүй нийт 239,239.6 мянган төгрөгийн үр ашиггүй, зориулалт бус зарцуулалт санхүүжүүлсэн байна. Үүнд: - "Эко интэрнейшл тауэр" барилгад оффисын 504.9 м.кв талбайн түрээс болон байр ашиглалтын зардалд 196,794.6 мянган төгрөг; - Байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ дотоод хүний нөөцийг ашиглалгүйгээр нийт 33,700.0 мянган төгрөгийн судалгааны ажлыг хувь хүн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлсэн; - "Газрын эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал" хэлэлцүүлэгийн катеринг үйлчилгээнд 1,595.0 мянган төгрөг; - Монгол Улсын байгаль орчны салбарт тулгамдаж буй асуудал</p>	1	239,239.6			1	239,239.6						

уулзалтыг зохион байгуулахад 7,150.0 мянган төгрөг.												
Хувь хүнтэй 18,200.0 мянган төгрөг, Хөгжлийн хөтөч НҮТББ-тай 19,800.0 мянган төгрөг, Ухаалаг засаглал ТББ- тай 25,870.0 мянган төгрөгийн, нийт 63,870.0 мянган төгрөгийн судалгааны ажил санхүүжүүлсэн боловч байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаагүй, хэрэгцээ шаардлагагүй, үр ашиггүй зарцуулалт гаргасан байна.	1	63,870.0			1	63,870.0						
Судалгааны ажил хийлгэх худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ижил төстэй байдлаар нь багцлаагүй, шууд худалдан авч болох бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарт багтааж Цахим Гэрэгэ ХХК-аар 18,300.0 мянган төгрөг, Нэйшнл судалгаа ХХК-аар 19,900.0 мянган төгрөг, Эй Ай Ложистикс Плас ХХК-аар 18,600.0 мянган төгрөг (үйл ажиллагааны чиглэлд	1	94,600.0			1	94,600.0				1	94,600.0	

<p>судалгаа хийх чиг үүрэг байхгүй), Экспетед ХХК-аар 19,200.0 мянган төгрөг (үйл ажиллагааны чиглэлд судалгаа хийх чиг үүрэг байхгүй), Энх Алтай Хөгжил Капитал ХХК-аар 18,600.0 мянган төгрөгийн ажил гүйцэтгүүлсэн байна. Тус судалгааны ажлуудыг байгууллагын үйл ажиллагаанд ашиглаагүй, үр ашиггүй зарцуулалт бөгөөд Аж ахуй нэгжийн эцсийн эзэмшигч нар нь харилцан хамааралгүй боловч тайлан нэг ижил хэв маяг, загвараар боловсруулагдсан байна.</p>												
<p>Байгууллагын ашиглаж байгаа санхүүгийн программ нь Сангийн яамнаас нийтэд мэдээлсэн Нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийн жагсаалтад багтаагүй, Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу</p>	1	-				1	-					

шинэчлэл хийгдээгүй байна. Ерөнхий журнал болон санхүүгийн тайлан дахь дансны код зөрүүтэй байгаагаас ерөнхий журналын гүйлгээгээр тулгалт хийх, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсанд үндэслэлтэй баталгаа өгөх боломжгүй байна.												
Байгууллагын бүртгэлийн дансны үлдэгдлийн баталгааг Сангийн яамны Төрийн сангийн мэргэжилтэнтэй тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.	1	-					1	-				
Байгууллагын үндсэн чиг үүрэгт хамааралгүй "Улсын аварга малчин..." шагнал гардуулах дотоод албан томилолтод 5 албан хаагчийг ажиллуулж, 1,900.0 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан байна.	1	1,900.0					1	1,900.0				
ЗГХХГ-ын даргын 2025.09.10-ны өдрийн А/125 дугаар тушаалаар зохион байгуулалтын бүтцийн нэгжийн орон	1	367,574.9					1	367,574.9				

<p>тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталсантай холбоотойгоор ТАЗ-ийн зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтоос шинэчлэн өөрчлөлт оруулах албан тушаалын тодорхойлолтуудын санал боловсруулж, ТАЗ-д хүргүүлсэн байна. Түүнчлэн, ЗГХХГ-ын даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/198 дугаар тушаалаар тус байгууллагын ТҮ-ний албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталсан байна. ТАЗ-өөс зөвшөөрөл олгоогүй, ТҮ-ний албан тушаалын тодорхойлолт шинэчлэн батлагдаагүй байхад ЗГХХГ-ын даргын 2025.09.10-ны өдрийн А/125 дугаар тушаалаар шинэчилсэн бүтцээр албан хаагчдыг томилон ажиллуулж байна.</p>											
<p>Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 460,836.3 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил,</p>	1	460,836.4				1	460,836.4				

бусад биет бус хөрөнгө бүртгэлтэй байна.												
Эдийн засгийн ангилал зөрчиж 66,619.7 мянган төгрөгийн зардал гаргасан байна. Үүнд: - Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 65,616.9 мянган төгрөгийг байрны түрээсийн зардалд; - Бараа үйлчилгээний бусад зардлаас 1,002.8 мянган төгрөгийг байр ашиглалтын зардал.	1	66,619.7					1	66,619.7				
Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар нь 2025 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 27-ний өдөр буюу хуулийн хугацаанд ирүүлээгүй.	1	-							1	-		
Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй дараах асуудлууд байна. Үүнд: - Бараа, ажил, үйлчилгээг шууд худалдан авах аргаар зохион байгуулахын тулд төсөвт өртгийг хуваасан;	1	419,214.0							1	419,214.0		

<p>- Өмнөх онд хэрэгжүүлж, санхүүжилтийг олгосон "Процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээ" зөвлөх үйлчилгээний гэрээг дүгнэж акт үйлдээгүй, ажлын тайланг ирүүлээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.</p> <p>- Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, албан тушаалын жагсаалтад гэрээт шинжээч, судлаач, зөвлөхийн орон тоо батлан, гэрээт ажилтантай шууд Хөдөлмөрийн гэрээ байгуулж, Төрийн албаны цалингийн шатлалын дагуу 419,214.0 мянган төгрөгийг цалингийн сангаас цалинжуулж байна.</p>												
Нийт дүн	20	2,555,020.3	2	18,942.8	10	1,219,932.5	6	896,931.0	2	419,214.0	1	94,600.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Ажилчдын ашиглаж буй зарим хөрөнгүүд нь марк загвараар коджуулсан тэмдэглэгээ бүхий наалтгүйгээс бүртгэлээрх нэр төрлийн хөрөнгийг эд хариуцагчийн карт руу тулгах боломжгүй байна.	1	-			1	-
Худалдан авах ажиллагааг тендер шалгаруулалтын харьцуулалтын аргаар үнийн санал дуудаж зохион байгуулахдаа хүчингүй болсон тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийг ашигласан байна.	1	-			1	-
Нийт дүн	2	-			2	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 231/А0170039
САГ-2026/94/НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар нь 2025 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 27-ний өдөр буюу хуулийн хугацаанд ирүүлээгүй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх", 70 дугаар зүйлийн 70.1-д "Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүй, албан үүргээ биелүүлээгүй Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын Ахлах нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Алтанзаяад сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дарга /Б.Батцэцэг/-т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Д.МӨНХЖИН
Г.ТЭЛМҮҮН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-37.Docx

1526180640



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 232/АД170039

Улаанбаатар хот

САГ-2026/94/НА-СТА-ТЦ.3

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй дараах асуудлууд байна. Үүнд:

- Бараа, ажил, үйлчилгээг шууд худалдан авах аргаар зохион байгуулахын тулд төсөвт өртгийг хуваасан;
- Өмнөх онд хэрэгжүүлж, санхүүжилтийг олгосон "Процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээ" зөвлөх үйлчилгээний гэрээг дүгнэж акт үйлдээгүй, ажлын тайланг ирүүлээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу;
- Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, албан тушаалын жагсаалтад гэрээт шинжээч, судлаач, зөвлөхийн орон тоо батлан, гэрээт ажилтантай шууд Хөдөлмөрийн гэрээ байгуулж, Төрийн албаны цалингийн шатлалын дагуу 419,213,971.90 /Дөрвөн зуун арван есөн сая хоёр зуун арван гурван мянга есөн зуун далан нэгэн төгрөг ерэн мөнгө/ төгрөгийг цалингийн сангаас цалинжуулж байна.


Төрийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн үйлчилгээний албан тушаалд төрийн үйлчилгээг адил тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэх болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах чиг үүрэг бүхий хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллах дараах албан тушаал хамаарна", 14.1.1-д "төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаал", 14.1.2-т "боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, урлаг, спорт зэрэг төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын дарга, захирал, эрхлэгч, бусад удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаал", 14.1.3-т "яам, агентлагийн харьяа болон түүний дэргэд ажилладаг, төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаал", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ.” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүй, албан үүргээ биелүүлээгүй буруутай албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дарга /Б.Батцэцэг/-т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Д.МӨНХЖИН
Г.ТЭЛМҮҮН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 233/АОН40039

Улаанбаатар хот

САТ-2026/94/НА-СТА-ТМЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн тодруулга, Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга, төсвийн тохируулгын тайланг иж бүрэн бэлтгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4-т "Санхүүгийн нэгтгэсэн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 54.4.5-д "санхүүгийн тайлангийн тодруулга", 54.5-д "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна", 54.5.4 "хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Өмнөх аудитаар "Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тэмдэглэл, урсгал төсвийн болон нэмэлт санхүүжилтийн тайлан, төсвийн тохируулгын тайланг холбогдох хууль, тогтоомжийн дагуу иж бүрэн бэлтгэн, толилуулж байх" зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дарга /Б.Батцэцэг/, ахлах нягтлан бодогч /Х.Алтанзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Д.МӨНХЖИН
Г.ТЭЛМҮҮН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-37.Docx

1526180620



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 234/А0170039

Улаанбаатар хот

САГ-2026/94/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд.

Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан үндэслэлээр, 17 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхээр 2 ажлын хэсэг байгуулагдаж, өөрийн үндсэн чиг үүргийн ажил гүйцэтгэснийг онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн гэж үзэн ажлын хэсгийн гишүүдэд нийт 110,646,000.00 /Нэг зуун арван сая зургаан зуун дөчин зургаан мянган/ төгрөгийн урамшууллыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон боловч онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн эсэхийг үнэлсэн шалгуур, үнэлгээний тайлан, хурлын тэмдэглэл байхгүй байна. Үүнд:

- "Өргөдөл, гомдлын бүртгэл, ангилал, шийдвэрлэлтийг нэгдсэн байдлаар хянаж, давхардлыг тогтоон, дүн шинжилгээ хийх..." ажлын хэсгийн 8 албан хаагчид 27,947,000.00 /Хорин долоон сая есөн зуун дөчин долоон мянган/ төгрөг;
- "Экспортыг нэмэгдүүлж, худалдааг дэмжих" ажлын хэсгийн 17 албан хаагчид 82,699,000.00 /Наян хоёр сая зургаан зуун ерэн есөн мянган/ төгрөгийн урамшууллыг тус тус олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4-р зүйлийн 4.1.3-т "үр ашигтай байх; 4.2.2-т "хэмнэлтийн горим нь иргэд, олон нийтийн ашиг сонирхолд нийцэж, тэдний дэмжлэгийг хүлээхүйц түвшинд тодорхойлогдсон байх", Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2 дугаар зүйлийн 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна.", Төрийн албан хаагчид шагнал олгох журмын 3 дугаар зүйлийн 3.3-т "Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-37.Docx

1526180632

1. Онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн эсэхийг үнэлсэн шалгуур, үнэлгээний тайлан, хурлын тэмдэглэл байхгүй урамшууллыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дарга /Б.Батцэцэг/, ахлах нягтлан бодогч /Х.Алтанзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР		П.ЧАНЦАЛДУЛАМ
АХЛАХ АУДИТОР		Д.МӨНХЖИН
АУДИТОР		Г.ТЭЛМҮҮН





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 235/АД170039

Улаанбаатар хот

САГ-2026/94/НА-СТА-ТЦЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ЗГХХГ-ын 9 албан хаагч Зургаан сараас дээш хугацаагаар түр орлон гүйцэтгэсэн тохиолдолд тус албан тушаалын цалингийн 40.0 хүртэлх хувиар түр орлон гүйцэтгүүлсний нэмэгдэл цалин олгохоор байгаа боловч тус 9 албан хаагчид эхний сараас эхлэн 40.0 хувийн нэмэгдэл цалин олгосноос 24,986,802.73 /Хорин дөрвөн сая есөн зуун наян зургаан мянга найман зуун хоёр төгрөг далан гурван мөнгө/ төгрөгийн зардал гарсан байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5-д "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална", Монгол улсын засгийн газрын 2019 оны 09 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журмын 2.2-т "Энэ журмын 2.1-д заасан түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үндсэн ажлаас гадна нэмэлт албан үүргийг түр орлон гүйцэтгэж холбогдох журамтай нийцээгүй нэмэлт цалин авсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дарга /Б.Батцэцэг/, ахлах нягтлан бодогч /Х.Алтанзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Д.МӨНХЖИН
Г.ТЭЛМҮҮН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-37.Docx

1526180644



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 236/АДИ-ТОО39

Улаанбаатар хот

САГ-2026/94/НА-СТА-ТЦЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн төсөлд тусгаж, батлуулаагүй нийт 239,239,568.00 / Хоёр зуун гучин есөн сая хоёр зуун гучин есөн мянга таван зуун жаран найман/ төгрөгийн үр ашиггүй, зориулалт бус зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- “Эко интэрнейшл тауэр” барилгад оффисын 504.9 м.кв талбайн түрээс болон байр ашиглалтын зардалд 196,794,568.00./Нэг зуун ерэн зургаан сая долоон зуун ерэн дөрвөн мянга таван зуун жаран найман/ төгрөг;
- Байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ дотоод хүний нөөцийг ашиглалгүйгээр нийт 33,700,000.00 /Гучин гурван сая долоон зуун мянган/ төгрөгийн судалгааны ажлыг хувь хүн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлсэн;
- “Газрын эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал” хэлэлцүүлгийн катеринг үйлчилгээнд 1,595,000.00 /Нэг сая таван зуун ерэн таван мянган/ төгрөг;
- Монгол Улсын байгаль орчны салбарт тулгамдаж буй асуудал уулзалтыг зохион байгуулахад 7,150,000.00 /Долоон сая нэг зуун тавин мянган/ төгрөг.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөвт батлагдаагүй, үр ашиггүй зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дарга /Б.Батцэцэг/, ахлах нягтлан бодогч /Х.Алтанзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Д.МӨНХЖИН
Г.ТЭЛМҮҮН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 237/АДИЯ0039

Улаанбаатар хот

САГ-2026/94/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Судалгааны ажил хийлгэх худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ижил төстэй байдлаар нь багцлаагүй, шууд худалдан авч болох бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарт багтааж "Цахим Гэрэгэ" ХХК-аар 18,300,000.00 /Арван найман сая гурван зуун мянган/ төгрөг, "Нэйшнл судалгаа" ХХК-аар 19,900,000.00 /Арван есөн сая есөн зуун мянган/ төгрөг, "Эй Ай Ложистикс Плас" ХХК-аар 18,600,000.00 /Арван найман сая зургаан зуун мянган/ төгрөг (үйл ажиллагааны чиглэлд судалгаа хийх чиг үүрэг байхгүй), "Эксептед" ХХК-аар 19,200,000.00 /Арван есөн сая хоёр зуун мянган/ төгрөг (үйл ажиллагааны чиглэлд судалгаа хийх чиг үүрэг байхгүй), "Энх Алтай Хөгжил Капитал" ХХК-аар 18,600,000.00 /Арван найман сая зургаан зуун мянган/ төгрөгийн ажил гүйцэтгүүлсэн байна. Тус судалгааны ажлуудыг байгууллагын үйл ажиллагаанд ашиглаагүй, үр ашиггүй зарцуулалт бөгөөд Аж ахуй нэгжийн эцсийн эзэмшигч нар нь харилцан хамааралгүй боловч тайлан нэг ижил хэв маяг, загвараар боловсруулагдсан байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална", 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6 дугаар зүйлийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах;", 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан," гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ижил төстэй байдлаар нь багцлаагүй, шууд худалдан авч болох бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарт багтааж, гэрээ байгуулсан бөгөөд хүлээн авсан нэг ижил хэв маяг, загвараар боловсруулсан судалгааны ажлуудыг байгууллагын үйл ажиллагаанд ашиглаагүй, зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дарга /Б.Батцэцэг/, ахлах нягтлан бодогч /Х.Алтанзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Д.МӨНХЖИН
Г.ТЭЛМҮҮН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 238/АД170039

Улаанбаатар хот

САГ-2026/94/НА-СТА-ТЦЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд.

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны А/05 дугаар тушаалын хавсралтад дурдсан ахлах хянан шалгагч болон хянан шалгагчид төсөвт батлагдаагүй, нийт 144,811,153.20 /Нэг зуун дөчин дөрвөн сая найман зуун арван нэгэн мянга нэг зуун тавин гурван төгрөг хорин мөнгө/ төгрөгийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл цалинг үндсэн цалингийн сангаас тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16-р зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөвт батлагдаагүй, хянан шалгагчид 40 хүртэлх хувийн нэмэгдэл цалин олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дарга /Б.Батцэцэг/, ахлах нягтлан бодогч /Х.Алтанзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Д.МӨНХЖИН
Г.ТЭЛМҮҮН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 239/АД-170039

Улаанбаатар хот

САГ-2026/94/МА-СТА-ТМЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хувь хүнтэй 18,200,000.00 /Арван найман сая хоёр зуун мянган/ төгрөг, "Хөгжлийн хөтөч" НҮТББ-тай 19,800,000.00 /Арван есөн сая найман зуун мянган/ төгрөг, "Ухаалаг засаглал" ТББ-тай 25,870,000.00 /Хорин таван сая найман зуун далан мянган/ төгрөг, нийт 63,870,000.00 /Жаран гурван сая найман зуун далан мянган/ төгрөгийн судалгааны ажил санхүүжүүлсэн боловч байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаагүй, хэрэгцээ шаардлагагүй, үр ашиггүй зарцуулалт гаргасан байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах," 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаагүй судалгааны ажилд үр ашиггүй зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дарга /Б.Батцэцэг/, ахлах нягтлан бодогч /Х.Алтанзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Д.МӨНХЖИН
Г.ТЭЛМҮҮН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26-230

Z: Alban Sheardlaga.2026/0125 SAG-37.Docx

1526180624



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 240/АОН0039

Улаанбаатар хот

САГ-2026/94/НА-СТА-ТЧЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамтай нийцээгүй мөнгөн тусламжийг олгосон дараах зөрчил илэрлээ. Үүнд:


- Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2025 оны А/01 дүгээр тушаалаар Хөдөлмөрийн дотоод журамд заасан магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллагын оношоор 2 сараас дээш хугацаагаар эмчилгээ хийлгэж байгаа тохиолдолд албан хаагчид 5,000,000.00 /Таван сая/ төгрөгийн мөнгөн тусламж олгохоор заасан боловч 1 албан хаагчид 18,000,000.00 /Арван найман сая/ төгрөгийн тусламж олгосон;
- Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2025 оны А/13 дугаар тушаалаар Хуулийн багийн гэрээт зөвлөхөд Хөдөлмөрийн дотоод журамд заасан 3,000,000.00 /Гурван сая/ төгрөгийн нэг удаагийн тусламж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;" , 16-р зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно.", 61 дүгээр зүйлийн 61.1-д "Төрийн албан хаагч дараахь нийтлэг баталгаагаар хангагдана", 61.1.1-д "албан тушаалын цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал, урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж авах", Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д "Хамтын гэрээгээр зохицуулах харилцааг талууд харилцан тохиролцох бөгөөд ажилтны хөдөлмөрлөх эрх, хууль ёсны ашиг сонирхолтой холбоотой дараах асуудлыг хамтын гэрээнд тусгаж болно", 37.1.3-т "ажил олгогчоос ажилтанд олгох тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийн хэмжээ", ЗГХХГ-ын даргын 2024 оны А/159 дүгээр тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журмын 12.1.2-т "Магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллагын оношоор Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтран баталсан "Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох баримтлах өвчний жагсаалт"-д орсон өвчний учир 2 сараас дээш хугацаагаар эмчилгээ хийлгэж байгаа тохиолдолд албан хаагчид 5,000,000 (таван сая) хүртэл төгрөгийн мөнгөн тусламж;" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.2.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал.” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасан мөнгөн тусламжийг хэтрүүлэн олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дарга /Б.Батцэцэг/, ахлах нягтлан бодогч /Х.Алтанзаяа/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Д.МӨНХЖИН
Г.ТЭЛМҮҮН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 241/АД170039

Улаанбаатар хот

САГ-2026/94/НА-СТА-ТМЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж дараах үр ашиггүй зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Брошур, тараах материал хэвлүүлэхэд 440,000.00 /Дөрвөн зуун дөчин мянган/ төгрөг;
- Сургалтын арга хэмжээнд бэлэг дурсгалын зүйл худалдан авахад 1,144,000.00 /Нэг сая нэг зуун дөчин дөрвөн мянган/ төгрөг;
- Байгууллагын бүтэц, дүрмийн шинэчлэлийг танилцуулах арга хэмжээг Тэрэлжид байрлах амралтын газар зохион байгуулахад 32,666,550.00 /Гучин хоёр сая зургаан зуун жаран зургаан мянга таван зуун тавин/ төгрөг;
- Арга хэмжээ хөтлөх хөтлөгчийн зардалд 3,000,000.00 /Гурван сая/ төгрөг;
- Байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авахад 260,000.00/Хоёр зуун жаран мянган/ төгрөг.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4-р зүйлийн 4.1.3-т "үр ашигтай байх; 4.2.2.хэмнэлтийн горим нь иргэд, олон нийтийн ашиг сонирхолд нийцэж, тэдний дэмжлэгийг хүлээхүйц түвшинд тодорхойлогдсон байх", 12-р зүйлийн 12.1.3-т "хэвлэлийн захиалгын төлбөр", 15-р зүйлийн 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", "15.1.7.байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах", 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүйгээс үр ашиггүй зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дарга /Б.Батцэцэг/, ахлах нягтлан бодогч /Х.Алтанзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Д.МӨНХЖИН
Г.ТЭЛМҮҮН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 242/АДИ70039

Улаанбаатар хот

САГ-2026/94/НА-СТА-ТМЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд.

Төсвийн төсөлд тусгаагүй 489,039,568.00 /Дөрвөн зуун наян есөн сая гучин есөн мянга таван зуун жаран найман/ төгрөг, үр ашиггүй 197,880,550.00 /Нэг зуун ерэн долоон сая найман зуун наян мянга таван зуун тавин/ төгрөгийн санхүүжилт олгож төсвийг зохистой удирдаагүйгээс 488,268,480.00 /Дөрвөн зуун наян найман сая хоёр зуун жаран найман мянга дөрвөн зуун наян/ төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;”, гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал.” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн төсөлд тусгаж, батлагдаагүй ажил үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулж, өр төлбөр үүсгэсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дарга /Б.Батцэцэг/, ахлах нягтлан бодогч /Х.Алтанзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Д.МӨНХЖИН
Г.ТЭЛМҮҮН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 37/А0170039

Улаанбаатар хот

САГ-2026/94/НА-СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн хөрөнгийн түүвэр тооллого хийхэд 6,538,242.50 /Зургаан сая таван зуун гучин найман мянга хоёр зуун дөчин хоёр төгрөг тавин мөнгө/ төгрөгийн үлдэх өртөгтэй Lenovo брэндийн Yogabook-9 загварын нөүтбүүк биетээр оршин байхгүй байна. Түүнчлэн, байгууллагын эд хөрөнгийн тооллогын комиссын дүгнэлтээр 3,869,551.36 /Гурван сая найман зуун жаран есөн мянга таван зуун тавин нэг төгрөг гучин зургаан мөнгө/төгрөгийн үлдэх өртөгтэй Ipad 13 pro загварын таблет дутсан байна.


Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.2.7-д “төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан” гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн 10,407,793.86 /Арван сая дөрвөн зуун долоон мянга долоон зуун ерэн гурван төгрөг наян зургаан мөнгө/ төгрөгийг Нярав Г.Ганбаяраар төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дарга /Б.Батцэцэг/, ахлах нягтлан бодогч /Х.Алтанзаяа/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Д.МӨНХЖИН
Г.ТЭЛМҮҮН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Aki\2026\0225_SAG-30.Docx

1526160472



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 38/АД/0039

Улаанбаатар хот

САГ-2026/94/НА-СТА-ТЧЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны А/05 дугаар тушаалаар тус газрын дарга өөрийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргаж, 8,535,000.00 /Найман сая таван зуун гучин таван мянган/ төгрөгийн нэмэгдэл цалин авсан байна.


Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

- Хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргаж, нэмэгдэл цалин авсан 8,535,000.00 /Найман сая таван зуун гучин таван мянган/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дарга /Б.Батцэцэг/, ахлах нягтлан бодогч /Х.Алтанзаяа/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Д.МӨНХЖИН
Г.ТЭЛМҮҮН